

## ХӨВСГӨЛ АЙМАГ ДАХЬ МӨРӨН НИСЭХ БУУДЛЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНД ХИЙСЭН ДОТООД АУДИТ, ХЯНАЛТ ШАЛГАЛТЫН ТОВЧ ТАЙЛАН

2021.08.31

Мөрөн сум  
1 дүгээр баг

ИНЕГ-ын даргын үүргийг түр орлон гүйцэтгэгчийн баталсан 2021 оны 08 дугаар сарын 18-ны өдрийн Хөвсгөл аймаг дахь Мөрөн нисэх буудлын үйл ажиллагаанд дотоод аудит, хяналт шалгалт хийх тухай 15/21 тоот удирдамжийн хүрээнд дотоод аудит, хяналт шалгалтыг хийлээ.

Батлагдсан удирдамжийн дагуу ИНЕГ-ын ДАА-ны ахлах аудитор Л.Жаргалсайхан, санхүүгийн хяналтын мэргэжилтэн Ж.Нямдэлгэр, Ж.Энэрэл нарын бүрэлдэхүүнтэй ажлын хэсэг 2021 оны 08 дугаар сарын 20-ны өдрөөс 2021 оны 08 дугаар сарын 31-ний өдрийг дуустал хугацаанд дотоод аудит, хяналт шалгалтыг хийсэн.

ИНЕГ-ын даргын баталсан удирдамжийн хүрээнд Хөвсгөл аймаг дахь Мөрөн нисэх буудлын 2020 оны 03 дугаар сарын 01-ний өдрөөс 2021 оны 08 дугаар сарын 01-ний өдрийг хүртэлх хугацааны захиргаа, хүний нөөцийн үйл ажиллагаа, нисэх буудлын даргын гаргасан тушаал шийдвэрийн эрх зүйн үндэслэл, хүний нөөц бүрдүүлэлт, үйл ажиллагаанд мөрдөгдөж буй дүрэм, журам болон дээд байгууллагаас өгсөн үүрэг даалгаврын хэрэгжилт, нягтлан бодох бүртгэлийн анхан шатны баримт бүрдүүлэлт, худалдан авалт, цалин хөлсний бодолт, олголт зэргийг үндсэн баримт нотолгоонд тулгуурлан шалгах, зарим эргэлзээтэй зүйлүүд дээр холбогдох албан тушаалтнаас тайлбар, тодруулга авч ажиллалаа.

Хөвсгөл аймаг дахь Мөрөн нисэх буудлын 2019-2020 оны санхүүгийн үйл ажиллагааны үр дүнд хийгдсэн аудитын шалгалтаар “Зөрчилгүй” санал дүгнэлт авсан байна.

Албан бичиг хэргийн хөтлөлт үг, үсэг, утга найруулгын алдаатай, албан бичгийн хаяг, тэргүүг стандартын дагуу хийгээгүй, хавсралт материалууд дутуу байгаа зөрчил давтагдан гарсаар байна.

Тушаалын төсөл боловсруулахдаа “Албан хэрэг хөтлөлтийн нийтлэг журам”-ыг мөрдөж ажиллаагүй байгаа нь бичиг хэрэг хариуцсан ажилтан заавар, журмаа уншиж судлаагүй, мэдлэггүй байгаатай холбоотой байна.

Мөрөн нисэх буудал нь 2018 онд MNS ISO9001:2015 стандартыг үйл ажиллагаандаа нэвтрүүлж, хэрэгжүүлж ажиллахаар СХЗГ-ын бүртгэлийн 147 дугаар гэрчилгээ авч байсан бол 2021 оныг “Олон улсын удирдлагын нэгдсэн тогтолцоо (чанар, аюулгүй ажиллагаа, ХАБЭА)”-г хэрэгжүүлэх жил болгон зарлаж менежментийн тогтолцоог бүрдүүлэхээр ажиллаж байна.

Хөвсгөл аймаг дахь Мөрөн нисэх буудлын даргын тушаалаар томилогдсон 2 ажилтан албан тушаалын тодорхойлолтод заагдсан мэргэшил болон туршлагын шаардлагыг хангахгүй байна.

Иргэний нисэхийн үндэсний төвийн зүгээс орон нутгийн Нисэх буудлуудын гүйцэтгэлийн төлөвлөгөөг хэрхэн боловсруулах, гүйцэтгэлийн зорилт, шалгуур үзүүлэлтийг тогтоох, тайлан гаргах, үнэлэх журмыг хэрэгжүүлэх талаар нэгдсэн чиглэл өгч, холбогдох арга хэмжээ авч хэрэгжүүлээгүй, төлөвлөгөөг батлаагүй. 2020 он, 2021 оны эхний хагас жилийн байдлаарх гүйцэтгэлийн төлөвлөгөөний биелэлтийг хянаагүй, үнэлээгүй байна.

Ажлын хэрэгцээнд олгогдсон бараа материалын шаардах хуудсыг тухай бүр бичиж холбогдох зардлын дансанд гүйлгээг хийдэггүйгээс бараа материалын биет үлдэгдэл нягтлан бодох бүртгэлээс зөрүүтэй байна.

Бараа материалыг бүртгэлд тусгахдаа хэмжих нэгж, тоо ширхэг болон барааны бүлгийг буруу сонгодог зөрчил давтагдан гарсаар байна.

Худалдан авах ажиллагааг зохион байгуулахдаа аймгийн Төрийн өмчийн газраар дамжуулан зохион байгуулж байсан нь нисэх буудлын ажилтнуудад хангалттай хэмээний туршлага, дадлага олоход дэм болсон байна. Ажилчдаа худалдан авах ажиллагааны сургалтад хамруулж, өөрсдийн нөөц бололцоогоор тендерийн үйл ажиллагаа зохион байгуулах боломжтой болсон байна.

Нислэгийн удирдагч нарын зэргийн нэмэгдлийн хугацаа дууссан байхад 2 нислэгийн удирдагчид нийт 1,424,580.00 төгрөгийн нэмэгдэл илүү олгосон байгаа нь журам, заавраа уншиж судлаагүй, мэддэггүйтэй холбоотой байна.

Ажил хавсран гүйцэтгэсний нэмэгдлийг олгохдоо тушаалд зааснаар гүйцэтгэлийн үр дүнг харгалзаж олгодоггүй байна.

Гэрээний төсөл боловсруулах, гэрээ байгуулах, төлөөлөх, бүртгэх, хадгалах, хяналт тавих, дүгнэх үйл явц ЗГ-ын тогтоолоор батлагдсан “Албан хэрэг хөтлөлтийн нийтлэг журам, ИНЕГ-ын даргын баталсан “Иргэний нисэхийн ерөнхий газарт гэрээ байгуулах журам”-ын дагуу явагдахгүй байна.

Шилэн дансны мэдээллийг буруу, дутуу мэдээлж байсан дутагдлаа 2021 онд залруулан ажиллаж байна.

Аудитын шалтгалтын үр дүнд гарсан алдаа, дутагдлын засаж, залруулах талаар тус нисэх буудалд 13 зөвлөмж өгсөн болно.

ДОТООД АУДИТЫН АЛБА